



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/294

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон төсөвт үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 3 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон төсөвт үйлдвэрийн газрын захирал нартай байгуулсан 2021 оны контрактыг дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Г.Хурцгэрэл	-(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	Л.Хаш-Эрдэнэ	-(Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Б.Золжаргал	-(Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
	Ж.Бодьгэрэл	-(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
	Н.Пагмадулам	-(Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтэн)
	М.Дөлгөөнбаяр	-(Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)
	Л.Ганхуяг	-Орон нутгийн өмчийн газрын дарга
	Б.Балдорж	-(Орон нутгийн өмчийн газрын өмчийн хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн)

2.

- (Үйлдвэрийн газрын захирал нар)


- (Үйлдвэрийн газрын нягтлан бодогч нар)

Нарийн бичгийн дарга: Р.Пүрэвдорж - (Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн)

2. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон төсөвт үйлдвэрийн газрын захирал нартай байгуулсан контрактыг 2022 оны 5 дугаар сард багтаан үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Хурцгэрэл)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 04 дүгээр сарын А/249 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



САМГАЛАНБААТАР